



МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 4 сарын 4 өдөр

Дугаар 109

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Аудитын хуулийн этгээдэд хийх чанарын хяналтын журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Г.Түвдэндорж/-т үүрэг болгосугай.



Б.ЧОЙЖИЛСҮРЭН

000206



Сангийн сайдын 2017 оны 4-р сарын 4-ний өдрийн дугаар тушаалын хавсралт

АУДИТЫН ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ХИЙХ ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Аудитын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор аудитын хуулийн этгээдэд хийх чанарын хяналтыг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2 Аудитын хуулийн этгээд нь аудитын үйл ажиллагааг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу явуулж байгаа эсэх болон аудитын үйл ажиллагааны чанарын хяналтыг байгууллагадаа хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавихад чанарын хяналт (цаашид "хяналт" гэх)-ын энэхүү журмын зорилго оршино.
- 1.3 Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар болон тухайлсан тушаалаар томилогдсон ажлын хэсэг (цаашид 'комисс' гэх) энэхүү журмын дагуу хяналтыг хэрэгжүүлнэ.
- 1.4 Журмын 1.3-т заасан комиссын бүрэлдэхүүнд Сангийн яам, Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт (ММНБИ) болон бусад эрх бүхий мэргэжлийн байгууллагыг оролцуулж болно.

Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

- 2.1 Энэ журамд заасан дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:
 - 2.1.1 Материаллаг нөлөөтэй гэж олж илрүүлсэн зөрчил нь аудитын хуулийн этгээдийн хийж гүйцэтгэсэн аудитын ажлын чанарт томоохон хэмжээний нөлөө үзүүлэхээр эрсдэлтэй байх эсвэл аудитын тайлан хэрэглэгчдийн шийдвэрт нөлөөлөхүйц эрсдэлтэй байх тохиолдлыг хэлнэ.
 - 2.1.2 Материаллаг нөлөөгүй гэж илрүүлсэн алдаа зөрчил нь тухайн шалгасан ажил болон цаашдын аудитын ажилд нөлөөлөх эрсдэлгүй байхыг ойлгоно.
 - 2.1.3 Тархмал нөлөө гэж олж илрүүлсэн алдаа зөрчил нь тухайн аудитын хуулийн этгээдийн гүйцэтгэсэн аудитын ажилд бүхэлд нь эсвэл ихэнх хэсэгт, эсвэл аудит хийсэн санхүүгийн тайлангийн хэд хэдэн үзүүлэлтэд нөлөөлөхөөр эрсдэлтэй байхыг хэлнэ.

Гурав. Чанарын хяналт шалгалт

- 3.1 Комисс нь аудитын чанарын хяналтыг Санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх бүхий этгээдийн баталсан холбогдох шийдвэрээр төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хэлбэрээр жил бүр хийж гүйцэтгэнэ.

3.2 Төлөвлөгөөт чанарын хяналтыг хувиарыг Санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх бүхий этгээдийн тушаалаар жил бүрийн эхэнд батлуулан, хэрэгжүүлнэ.

3.3 Төлөвлөгөөт бус чанарын хяналтыг хууль, хяналтын байгууллагаас ирүүлсэн албан хүсэлт, шийдвэр мөн үйлчлүүлэгчдээс ирүүлсэн хүсэлт, өргөдөл, гомдлыг үндэслэн явуулах бөгөөд дараах зөрчлүүд байгаа эсэхэд чиглүүлэн зохион байгуулна:

3.3.1 Аудитын үйл ажиллагааг Аудитын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу явуулсан эсэх;

3.3.2 Санхүүгийн тайланг хуурамчаар баталгаажуулсан эсэх

3.3.3 АОУС-аар шаардсан аудитын горим гүйцэтгэхэд Сангийн сайдын тушаалаар батлагдсан “Аудитын үйлчилгээний төлбөрийн хэмжээ, хугацааны жишиг”-ээс хэт зөрүүтэй, богино хугацаанд хийж гүйцэтгэсэн эсэх;

3.3.4 Шударга өрсөлдөөний зарчмыг мөрдөөгүй, үйлчлүүлэгчдийг төөрөгдүүлж, өөрийн байгууллагыг бусад аудитын хуулийн этгээдтэй харьцуулах болон тэдний нэр төрд харшлах үйлдэл гаргасан эсэх;

3.4 Сангийн яамны холбогдох газар болон аймаг, нийслэл, дүүргийн нягтлан бодох бүртгэл, аудитын асуудал хариуцсан мэргэжилтнүүд нь аудитын хуулийн этгээдэд зайны хяналтыг тавьж болно.

3.4.1 Зайны хяналтаар аудитын хуулийн этгээдийг хууль тогтоомж болон сайдын тушаалаар батлагдсан заавар журмыг хэрхэн ханган ажиллаж байгаад хяналт тавина.

3.5 Чанарын хяналт шалгалт нь аудитын байгууллагын түвшинд хийх шалгалт, хийж гүйцэтгэсэн аудитын ажлын баримтанд хийх шалгалт гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ.

3.6 Аудитын байгууллагын түвшинд хийх хяналт шалгалтаар дараах ажлыг хянан, үнэлж, зөвлөмж өгнө. Үүнд:

3.6.1 Аудитын ажлын чанарыг хангахад байгууллагын тогтолцооны түвшинд аудитын удирдлагын бодлого, горим нь зохистой, үр нөлөөтэй зохион байгуулагдсан эсэх;

3.6.2 Аудит, баталгаажуулалтын ажлыг хийхэд мөрддөг дотоодын бодлого журам нь аудитын болон бусад холбогдох баталгаажуулах ажлын олон улсын стандарттай нийцэж буй эсэх;

3.6.3 Аудитын үйл ажиллагааг зохих стандарт, дүрэм журмын дагуу чанартай гүйцэтгэхэд шаардлагатай дотоодын чанарын хяналтыг хийдэг эсэх;

3.6.4 Аудитын чанарыг хангахуйц хүний нөөцтэй, тэдгээрт зориулсан бодлогоор зохицуулагдсан чиг үүргүүд нь тухайн аудитын хуулийн этгээдийн аудитын бодлого, арга зүй, стандарт, гарын авлага, дүрэм, журмын дагуу бэлтгэгдсэн эсэх;

- 3.6.5 Аудитын хуулийн этгээд нь ёс зүйн шаардлагууд болон хараат бус байдлаа хадгалахтай холбоотой дүрэм журмыг мөрддөг эсэх;
- 3.6.6 Олон нийтийн ашиг сонирхолын аж ахуйн нэгж ("ОНАСААН")-д аудит, баталгаажуулалтын үйлчилгээ үзүүлэхдээ холбогдох олон улсын стандартаар шаардсан бодлого, горим болон хугацааг төлөвлөж гүйцэтгэдэг эсэх.
- 3.7 Аудитын хуулийн этгээдийн хийж гүйцэтгэсэн аудитын ажлын баримтанд хийх шалгалтаар дараах ажлыг хянан, үнэлж, зөвлөмж өгнө. Үүнд:
- 3.7.1 Аудитын хуулийн этгээдийн батлан дотооддоо мөрдөж буй аудит, нягтлах шалгалт, бусад баталгаажуулалтын ажлын бодлого, горим, журмуудыг баримталж ажилладаг эсэх;
- 3.7.2 Үйлчлүүлэгч байгууллагынхаа санхүүгийн тайлан бэлтгэсэн байдлыг үнэлж, дүгнэлт өгөхдөө Нягтлан Бодогчдын Олон Улсын Холбооноос (НБОУХ) гаргасан холбогдох санхүүгийн тайлагналын олон улсын стандартын мөрдөлтийг шалгахад чиглэсэн аудитын горим гүйцэтгэж байгаа эсэх;
- 3.7.3 Аудитор нь аудит, баталгаажуулалтын ажлыг хангалттай зохистой нотолгоонд үндэслэн баримтжуулдаг эсэх;
- 3.7.4 Аудиторууд нь мэргэжлийн шийдэл гаргахдаа холбогдох олон улсын стандарт болон хууль тогтоомжийн шаардлагыг мөрдөж ажиллаж байгаа эсэх.
- 3.8 Энэ журмын 3.5-д заасан байгууллагын түвшинд хийх чанарын хяналтыг зайнаас эсвэл комиссоос баталсан загварын дагуу аудитын байгууллагыг өөрийг нь өөрөөр нь үнэлүүлж, үр дүнг нь хянах замаар хийж болно.

Дөрөв. Хяналтыг хэрэгжүүлэгч этгээдэд тавигдах шаардлага, түүний эрх үүрэг

- 4.1 Чанарын хяналт шалгалтыг хэрэгжүүлэгч этгээдэд дараах шаардлага тавигдана:
- 4.1.1 Санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хувьд тус байгууллагад ажилладаг мэргэжилтэн байх;
- 4.1.2 Чанарын хяналтыг хэрэгжүүлэх комиссын гишүүдийн хувьд хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагаас албан ёсоор томилогдож үүрэг хүлээсэн тухайн байгууллагад ажилладаг, аудитын болон нягтлан бодох бүртгэлийн мэдлэг, туршлагатай ажилтан байх.
- 4.2 Чанарын хяналтыг хэрэгжүүлэгч дараах эрх, үүргийг эдэлнэ.
- 4.2.1 Чанарын хяналтыг хараат бусаар, мэргэжлийн өндөр түвшинд, хууль тогтоомж, холбогдох олон улсын стандартын дагуу явуулах үүрэг хүлээнэ.

- 4.2.2 Хяналт шалгалтад шаардлагатай баримт, материалыг гаргуулж авах, стандартын дагуу үнэлж, дүгнэлтээ хараат бусаар гаргах.
- 4.2.3 Хяналт шалгалтын комисс нь энэ журмын хавсралт 1-ээр баталсан “Аудитын байгууллагын түвшинд хийх чанарын хяналтын Асуулгын хуудас”, журмын 2 дугаар хавсралтаар баталсан “Аудитын ажлын түвшинд хийх Чанарын хяналтын Шалгах хуудас”-ыг чанарын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах бүртээ шалгуулж буй байгууллагын онцлог, тухайн үед шинээр гарсан стандарт, хууль тогтоомжийн шаардлагатай нийцүүлэн шинэчлэн сайжруулж ашиглах үүрэгтэй.
- 4.2.4 Мэргэжлийн ёс зүйн талаар ММНБИ-ээс лавлагаа гаргуулж авах.
- 4.2.5 Шалгалтын явцад илрүүлсэн зөрчил, дутагдлын талаарх мэдээллийг бусдад дамжуулах, хувийн зорилгоор ашиглах, шалгалтын дүнг гуйвуулах, шалгалт дуусаагүй эсвэл нэгдсэн дүгнэлт гараагүй байхад урьдчилсан дүгнэлт гаргах, мэдээ, мэдээлэл тараах, хууль бус үйлдлийг нуун дарагдуулах, авлигад өртөх, бусдад дарамт шахалт үзүүлэхийг хориглоно.
- 4.2.6 Шалгалтын комисс нь гаргасан дүгнэлтийнхээ үндэслэлийг бичгээр болон амаар тайлбарлах эрхтэй.
- 4.2.7 Комисс нь чанарын хяналтын талаарх дүгнэлтийг багтаасан тайлан бэлтгэж, аудитын хуулийн этгээдэд хүргүүлэн, алдаа дутагдлыг хэрхэн залруулахад талаар төлөвлөгөө гаргуулан авч үнэлэн дүгнэнэ
- 4.3 Аудитын нэг байгууллагад чанарын хяналтыг хийж хэрэгжүүлэх комиссийн бүрэлдэхүүн нь 3-аас доошгүй хүнтэй байна.
- 4.4 Комиссын гишүүн нь “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль”-ийн 3.1.5-д заасан хамаарал бүхий этгээдийг хянан шалгахгүй.
- 4.5 Чанарын хяналтыг хэрэгжүүлэгч төрийн захиргааны төв байгууллага нь Улсын хэмжээнд аудит, баталгаажуулалтын үйлчилгээний чанарын хяналтын бодлогыг тодорхойлох үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тав. Аудитын хуулийн этгээдийн эрх, үүрэг

- 5.1 Хяналт шалгалтад шаардлагатай баримт материалыг цаг хугацаанд нь гаргаж, хүлээлгэн өгөх
- 5.2 Жил бүрийн 6 дугаар сарын 1-ний өдрийн дотор үйлчилгээ үзүүлсэн, үзүүлж байгаа байгууллагын жагсаалтыг Сангийн яамны холбогдох газарт хүргүүлнэ.
- 5.3 Хяналт шалгалт явуулах нөхцөл бололцоо, ажлын байраар хангах;
- 5.4 Шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг шуурхай залруулах;
- 5.5 Хяналт шалгалтын явцад саад учруулахгүй, хөндлөнгөөс оролцохгүй, албан тушаал, байгууллагын нэрээр бусдыг дарамтлах, нөлөөлөх, шахалт үзүүлэхгүй байх;
- 5.6 Шалгалтын дүгнэлтийн талаар тайлбар өгөхийг шаардах эрхтэй.

Зургаа. Чанарын хяналт шалгалт хийх хугацаа

- 6.1 Комисс нь аудитын нэг хуулийн этгээдэд хийх чанарын хяналтын шалгалтыг батлагдсан удирдамжийн дагуу томилсон хугацаанд тухайн байгууллагын хэвийн үйл ажиллагаанд нөлөөлөхгүйгээр шуурхай гүйцэтгэнэ. Шаардлагатай тохиолдолд эрх бүхий удирдлагад мэдэгдэн, энэхүү хугацааг сунгаж болно.
- 6.2 Төлөвлөгөөт чанарын хяналт шалгалт хийх талаар аудитын хуулийн этгээдэд хяналт шалгалт эхлэхээс өмнө мэдэгдэнэ. Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх бол урьдчилан мэдэгдэхгүй байж болно.
- 6.3 Аудитын хуулийн этгээдийн хэрэгжүүлдэг процесс ба үйл явц, аргачлал, ажлын баримт зэргийг зохих чанарын шалгууруудын дагуу үнэлж дүгнэнэ. Шалгах зүйлийг сонгохдоо санамсаргүй түүврийн арга болон олон нийтийн ашиг сонирхолд хэр хүчтэй нөлөөтэй байдлыг харгалзан үзнэ.

Долоо. Чанарын хяналт шалгалтын нэгдсэн дүгнэлт, тайлагнал

- 7.1 Чанарын хяналт шалгалтын дүгнэлт нь "Бүрэн хангалттай", "Хангалттай", "Тодорхой нөхцөл хангасан тохиолдолд хангалттай", "Хангалтгүй" гэсэн үнэлгээтэй байна.
- 7.2 Аудитын хуулийн этгээдэд хийх аудитын чанарын хяналтын шалгалтыг журмын 1 дүгээр хавсралтаар баталсан "Аудитын байгууллагын түвшинд хийх чанарын хяналтын Асуулгын хуудас", журмын 2 дугаар хавсралтаар баталсан "Аудитын ажлын түвшинд хийх Чанарын хяналтын Шалгах хуудас", журмын 3 дугаар хавсралтаар баталсан "Илрүүлэлтийн жагсаалт", журмын 4 дүгээр хавсралтаар баталсан "Чанарын хяналтын нэгдсэн тайлангийн загвар" зэргийг ашиглан явуулна.

7.3 Шалгалтын комисс нь чанарын хяналтын “Асуулгын хуудас” болон “Шалгах хуудас”-д багтсан асуулт тус бүрт хариулт авч, аудитын байгууллагын түвшинд тогтоосон систем болон хийж гүйцэтгэсэн ажлыг шалгасан баримттай холбоотой хариулт тус бүрт 0–ээс 3 хүртэл онооны үнэлгээ өгөх замаар чанарын хяналтын шалгалтын үр дүнг үнэлж, дүгнэнэ. Үүнд:

Үнэлгээ (оноогоор)	Харгалзах дүгнэлт
3	“Бүрэн хангалттай”
2	“Хангалттай”
1	“Тодорхой нөхцөл хангасан тохиолдолд хангалттай”
0	“Хангалтгүй”
ү/х	“үл хамаарна”

7.4 Үнэлгээний оноо өгөхдөө дараах зарчмыг баримтална:

- 7.4.1 Асуулгын хуудас болон Шалгах хуудаст дурдсан асуултад “Тийм” гэсэн хариулт өгч, тухайн хариулт нь комиссын бататгах шалгалтаар нотлогдсон тохиолдолд “3” буюу **“Бүрэн Хангалттай”** гэсэн үнэлгээ өгнө.
- 7.4.2 Асуулгын хуудас болон Шалгах хуудаст дурдсан асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн боловч нотлох шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал нь материаллаг нөлөөгүй, эсвэл цаашдын аудитын чанарт тархмал нөлөөгүй байх тохиолдолд “2” буюу “Хангалттай” гэсэн үнэлгээ өгч, зөрчлийн шалтгаан, утгыг журмын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Илрүүлэлтийн жагсаалт”-д тэмдэглэнэ. баримтжуулна.
- 7.4.3 Асуулгын хуудас болон Шалгах хуудаст дурдсан асуултад “Тийм” гэсэн хариулт өгч, тухайн хариултыг бататгах шалгалтаар зөрчил илэрсэн бөгөөд тухайн зөрчил дутагдал нь материаллаг эсвэл тархмал нөлөөтэй байх тохиолдолд “1” буюу “Тодорхой нөхцөл хангасан тохиолдолд хангалттай” гэсэн үнэлгээ өгч, зөрчлийн шалтгаан, утгыг **Илрүүлэлтийн жагсаалтад** тэмдэглэн баримтжуулна.
- 7.4.4 Асуулгын хуудас болон Шалгах хуудаст дурдсан асуултад “Үгүй” гэсэн хариулт өгсөн эсвэл “Тийм” гэсэн хариулт нь бататгах шалгалтаар батлагдаагүй байх бөгөөд тухайн зөрчил дутагдал нь “аудитын чанарт тархмал бөгөөд материаллаг нөлөөтэй” байх тохиолдолд “0” буюу “Хангалтгүй” гэсэн үнэлгээ өгч, зөрчлийн шалтгаан болон утгыг **Илрүүлэлтийн жагсаалтад** тэмдэглэн баримтжуулна.
- 7.4.5 Аудитын байгууллагын түвшинд хийсэн шалгалт болон сонгож шалгасан ажлын баримтын шалгатын үнэлгээг нэгтгэн нэгдсэн үнэлгээ гаргана..
- 7.4.6 “ү/х” буюу “Үл хамаарна” гэсэн тэмдэглэгээг зөвхөн хүндэтгэх шалтгаантай тохиолдолд ашиглах ба ашигласан тохиолдолд шалтгааныг нь тайлбарлана.

7.5 Шалгалтын хэсэг тус бүрийн эцэст нийт авсан оноог авах ёстой оноонд хувь тэнцүүлэх арга ашиглан нийт үнэлгээг гаргаж, Хүснэгт 1-ийг ашиглан эцсийн үнэлгээ өгнө. Нийт авбал зохих оноог тодорхойлоход “ү/х” гэсэн хариултыг оруулахгүй.

Хүснэгт 1

Гүйцэтгэлийн хувь	Үнэлгээ
> = 90%	Бүрэн хангалттай
75% - <90%	Хангалттай
50% - <75%	Тодорхой нөхцөл хангасан тохиолдолд хангалттай
<50%	Хангалтгүй

7.6 Аудитын хяналт шалгалтын нэгдсэн дүгнэлтийг үндэслэн аудитын хуулийн этгээдэд дараах арга хэмжээг авна. Үүнд:

7.6.1 “Хангалттай” гэсэн үнэлгээ авсан тохиолдолд илэрсэн зөрчил дутагдлын талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах тухай албан тоот хүргүүлэх;

7.6.2 “Тодорхой нөхцөл хангасан тохиолдолд хангалттай” гэсэн үнэлгээ авсан тохиолдолд зөрчил арилгах талаар ажлын төлөвлөгөө гаргаж ирүүлэх тухай хугацаатай албан шаардлагыг хүргүүлэх;

7.6.3 Журмын 7.6.2-д заасан шаардлагыг биелүүлээгүй эсвэл албан шаардлагад заасан хугацаанд зөрчлөө арилгаагүй тохиолдолд хуулийн этгээдийн аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авах санал боловсруулан дээд шатны удирдлагад танилцуулан, шийдвэр гаргуулах;

7.6.4 “Хангалтгүй” үнэлгээ авсан тохиолдолд хуульд заасны дагуу хуулийн этгээдийн аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авах санал боловсруулан дээд шатны удирдлагад танилцуулан, шийдвэр гаргуулах.

7.7 Чанарын хяналтын шалгалтын үр дүнг хэлэлцсэний дараа аудитын чанарын хяналт шалгалтын нэгдсэн тайланг 2 хувь үйлдэн шалгалтын комиссын дарга, гишүүд гарын үсэг зурах бөгөөд тайланг шалгуулсан этгээдэд танилцуулан, 1 хувийг өгнө. Шалгуулагч этгээд шалгалтын үр дүнтэй танилцаж гарын үсэг зурах ба гарын үсэг зурахаас татгалзсан бол энэ тухай тайлбарыг хавсаргана. Шалгуулсан этгээд тайлантай танилцаж гарын үсэг зурахаас татгалзсан нь түүнийг хүчин төгөлдөр бус гэж үзэх үндэслэл болохгүй.

7.8 Шалгалтын эцсийн үр дүнг аудитын хуулийн этгээд хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Стандартын хороогоор хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.


Найм. Аудитын чанарын хяналт шалгалт хийх, шалгах ажлын баримтыг сонгох арга

8.1 Чанарын хяналт шалгалтыг дараах аргуудыг ашиглан явуулж болно.

- 8.1.1 Бичиг баримтыг шалгах;
 - 8.1.2 Биет ажиглалт хийх;
 - 8.1.3 Загвар Асуулга, Шалгах хуудас ашиглан ярилцлага хийх
 - 8.1.4 Судалгаа авах
 - 8.1.5 Гаднын хэрэглэгчдээс мэдээлэл авах
- 8.2 Аудитын чанарын хяналтын шалгалтыг гүйцэтгэхээр томилогдсон комисс нь шалгалтаа зохион байгуулж, үр дүнг үнэлэхдээ энэ журмын Хавсралт 1 ба 2-д заасан Загвар асуулгын хуудас, Загвар шалгах хуудасыг ашиглахын хамт энэ журмын 9.1-д заасан аргуудыг хослуулан хэрэглэж болно.
- 8.3 Аудитын хуулийн этгээдэд чанарын хяналт шалгалт хийх мэдэгдэл хүргүүлэх үедээ тухайн мэдэгдэлд заасан хугацаанд багтаан бэлтгэж шалгалтын комисст ирүүлэх мэдээлэл, шаардлагатай материалын жагсаалтыг урьдчилан хүргүүлж, шалгалтын бэлтгэлийг хангуулах бодлого баримтална.
- 8.4 Аудитын чанарын хяналтыг хэрэгжүүлэгч нь аудитын хуулийн этгээдийн хийж гүйцэтгэсэн ажлын чанарыг үнэлэхдээ тухайн шалгуулагч аудитын хуулийн этгээдийн хийж гүйцэтгэсэн аудитын ажлаас санамсаргүй түүврийн арга болон эрсдэлд суурилсан шинжилгээний аргын аль тохиромжтой хувилбарыг сонгон дэлгэрэнгүй шалгах ажлын жагсаалтыг гаргана.
- 8.5 Чанарын хяналтын комисс нь чанарын хяналтын дэлгэрэнгүй шалгалтад хамруулах ажлыг сонгохдоо дараах аргачлалыг баримтлахыг энэхүү журам дэмжинэ:
- 8.5.1 Нийт аудит, баталгаажуулалтын үйлчилгээ үзүүлсэн харилцагчдын жагсаалтыг аудитын хуулийн этгээдээс гаргуулан авч уг жагсаалтыг Групп аж ахуйн нэгж (ААН), ОНАСААН ба бусад гэсэн ангиллаар ангилж, уг жагсаалтын Групп ААН-ээс 1, ОНАСААН-ээс 1 ажил, бусад ААН-ээс 1 ажлыг эрсдэлд суурилсан шинжилгээнд суурилан сонгоно.
 - 8.5.2 Хэрэв тухайн аудитын хуулийн этгээд групп болон ОНАСААН-д аудитын үйлчилгээ үзүүлдэггүй бол үйлчлүүлэгчийн жагсаалтаас санамсаргүй түүврийн аргаар гурван ААН-ийг сонгож тэдгээртэй холбоотой бүрдүүлсэн ажлын баримтад нь чанарын хяналтын шалгалт хийнэ.
 - 8.5.3 Комиссын даргаар батлуулсан Шалгах хуудас дахь мэдээллийг Аудитын ажлын баримт шалгах түүвэрт сонгогдсон ажил тус дээр бэлтгэнэ.

Ес. Үйлчилгээ үзүүлсэн байгууллагын жагсаалтыг хүргүүлэх.

- 9.1 Аудитын хуулийн этгээд жил бүрийн 6 дугаар сарын 1-ний өдрийн дотор үйлчилгээ үзүүлсэн, үзүүлж байгаа байгууллагын жагсаалтыг Сангийн яамны холбогдох газарт хүргүүлнэ.



Сангийн сайдын 2017 оны 100 тоот тушаалаар батлагдсан "Аудитын хуулийн этгээдэд хийх чанарын хяналтын журам"-ын хавсралт 1

АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ТҮВШИНД ХИЙХ ЧАНАРЫН ХЯНАЛТЫН АСУУЛГЫН ХУУДАС

Хүснэгт 1: Компанийн Аудитын тухай хуулийн шаардлагыг хангаж буй байдлын үнэлгээний асуулгын хуудас

Зорилго: Энэхүү асуулгын хуудас нь "Аудитын хуулийн этгээдийн Аудитын тухай хуулиар шаардсан шаардлагыг хангаж буй эсэх"-ийг үнэлэхэд зориулагдсан.

Зааварчилгаа:

- Тухайн асуулгын илрүүлэлт нь эерэг бол "Хариулт" багананд "Т" тэмдэглэгээ хийнэ.
- Харин илрүүлэлт нь сөрөг бол "Хариулт" багананд "Ү" гэсэн хариулт өгч, "Илрүүлсэн зөрчил" багананд шалтгааныг тайлбарлаж, энэ сөрөг хариултын талаар удирдлагатай хийсэн уулзалтын тэмдэглэлийг ишлэл болгоно.
- Хэрэв асуултын хариулт "Ү" гэж тэмдэглэгдсэн ч илрүүлэлтийн нөхцөл байдал нь Монгол улсын хууль тогтоомжтой нийцээгүй ч АОУС-тай нийцэхээр байвал зохих тайлбарыг мөн оруулбал зохино.
- Хэрэв асуулт нь тухайн аудитын хуулийн этгээдэд тохиромжгүй бол хариулт багананд "ү/х" тэмдэглэгээ оруулна.

№	Асуулт	Хариулт Т/Ү/(ү/х)	Тайлбар тэмдэглэл	Үнэлгээ
1.1	Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогч эсэх? Дүрэм, МНБ-ийн гэрчилгээтэй тулгаж үз.			
1.2	Захирал, партнер нь мэргэшсэн нягтлан бодогчийн хугацаагүй эрхтэй, Институтээс зохих зөвшөөрөл авсан эсэх? Холбогдох бичиг баримтыг үз.			
1.3	Тус компанид хоёроос доошгүй үндсэн орон тооны, хугацаагүй эрхтэй мэргэшсэн нягтлан бодогч ажилладаг эсэх? Нийгмийн даатгалын дэвтэр, цагийн бүртгэл, тушаал, Аудит хийсэн ажлын баримт дах баримт бүрдэлттэй тулгаж үз.			
1.4	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.1-д заасан стандартыг мөрдөх аж ахуйн нэгж, байгууллагад аудитын үйлчилгээ үзүүлдэг бол дөрвөөс доошгүй хугацаагүй эрхтэй мэргэшсэн нягтлан бодогчтой эсэх? Нийгмийн даатгалын дэвтэр, цагийн бүртгэл,			

№	Асуулт	Хариулт Т/Ү/(Ү/х)	Тайлбар тэмдэглэл	Үнэлгээ
	Аудит хийсэн ажлын баримт дах баримт бүрдэлттэй тулгаж үз.			
1.5	Аудиторууд нь мэргэжлийн ёс зүйн зөрчилгүй болохыг нотолсон нотолгоо бий эсэх? Аудиторын жагсаалтаар ММНБИ-ээс лавлагаа авах.			
1.6	Компани нь үйл ажиллагаа явуулах ажлын байртай эсэх? Түрээсийн гэрээ болон адилтгах нотлох баримттай тулгаж үз.			
1.7	Аудитор, туслах ажилтнууд нь аудитыг явуулахад хүрэлцээтэй техник хэрэгслээр хангагдсан эсэх? Шалгалтын явцад биечлэн үзэж танилцах. (компьютер, ширээ сандал, гарын авлага, ажлаа хэвийн хийхэд зайлшгүй шаардлагатай бусад зүйлс орно)			
1.8	Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь гадаадын байгууллага бол тухайн байгууллагын нийт мэргэшсэн нягтлан бодогчдын гуравны хоёроос доошгүй хувь нь Монгол улсын иргэн эсэх? Холбогдох мэдээллийг гаргуулан авч тулгах.			
1.9	Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь гадаадын байгууллага бол тухайн байгууллагын нийт хувьцаа эзэмшлийн гуравны нэгээс доошгүй хувийг Монгол Улсын иргэн, мэргэшсэн нягтлан бодогч эзэмшиж буй эсэх? Гэрээ, дүрэмтэй тулгаж, холбогдох мэргэшсэн нягтлан бодогчтой уулзаж ярилцаж баталгаажуул. (аудит, баталгаажуулалтын бус үйлчилгээ хариуцсан этгээдэд энэ асуулт үл хамаарна)			
1.10	Аудитын үйл ажиллагаа нь олон улсын стандартад нийцэж буй эсэх? Шалгасан ажлын баримтдаа суурилан энэ асуултад хариулна.			
1.11	Аудитын хуулийн этгээд нь салбартай бол салбарт үндсэн орон тооны нэгээс доошгүй аудитор ажиллаж буй эсэх?			

№	Асуулт	Хариулт Т/Ү/(Ү/Х)	Тайлбар тэмдэглэл	Үнэлгээ
	Нийгмийн даатгалын дэвтэр, цагийн бүртгэл, Аудит хийсэн ажлын баримт дах баримт бүрдэлттэй тулгаж үз.			
1.12	Тухайн аудитын байгууллагад ажилладаг мэргэшсэн нягтлан бодогч нар өөр байгууллагад давхар ажил эрхэлдэггүй эсэх? (олон нийтийн сонгуульт ажил, мэргэжил хөгжүүлэх зорилготой манлайллын чиг үүрэгт хамаарах ажил үл хамаарна) (Үндсэн орон тооны аудиторуудын талаар Нийгмийн даатгалаас лавлагаа авч тулгах.)			
1.13	Тухайн аудитын байгууллагад ажилладаг мэргэшсэн нягтлан бодогч нар бусад аудитын хуулийн этгээдэд гэрээгээр ажилладаггүй эсэх?			
1.14	ЧШ-ын явцад болон ЧШ-аас өмнө танд тус компани санхүүгийн тайланг хуурамчаар баталгаажуулсан гэдгийг сануулсан мэдээлэл ирээгүй эсэх? Ийм мэдээлэл ирсэн бол энэ мэдээллийг бататгах тодруулгыг компанийн удирдлагаас авах. Ийм мэдээллийг үгүйсгэх хангалттай нотолгоо тус компанид байгаа эсэхийг тодруулж тэмдэглэх.			
1.15	Аудитын хуулийн этгээд өөрөө татвар ногдуулах орлогоо нуун дарагдуулах, бууруулж тайлагнах гэх мэтээр хууль тогтоомж, журмыг зөрчөөгүй ажилласан эсэх? Аудитын хуулийн этгээд өөрөө шударга гэдгийг илтгэх ямар нэгэн баталгаа бий эсэх?			
1.16	Аудитын хуулийн этгээд нь мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулсан эсэх?			
1.17	Аудитын хуулийн этгээд аудитыг гэрээний үндсэн дээр гүйцэтгэдэг эсэх?			
	НИЙТ АВАХ ЁСТОЙ ОНОО			
1.20	1 хэсгийн бүлгийн нийт оноо			

№	Асуулт	Хариулт Т/Ү/(ү/х)	Тайлбар тэмдэглэл	Үнэлгээ
	Дээрх асуултуудад аль нэгэнд нь “Ү” гэсэн хариулт авсан, эсвэл “Т” хариулт авсан ч нотлох шалгалтаар батлагдаагүй бол тухайн хариултын нөлөөг үнэлэх замаар эдгээр үнэлгээний аль тохиромжтойг сонгож эцсийн үнэлгээ өгнө.	Бүрэн Хангалттай		
		Хангалттай		
		Тодорхой нөхцөл хангасан тохиолдолд хангалттай		
		Хангалтгүй		

Шалгалтын комисс:

Дарга

Гишүүд

/

/

/

/

/

/

Танилцаж зөвшөөрсөн

Гүйцэтгэх захирал

/

/

Хүснэгт 2: Компанийн аудит, баталгаажуулалтын манлайлал, удирдлагын тогтолцооны хяналтын үнэлгээний асуулгын хуудас

Зорилго: Энэхүү асуулгын хуудас нь "Аудитын чанарыг хангахад байгууллагын тогтолцооны түвшинд аудитын чанарын удирдлагын бодлого, горим нь зохистой, үр нөлөөтэй зохион байгуулагдсан эсэх"-ийг үнэлэхэд зориулагдсан.

№	Асуулт	Хариулт Т/Ү/И(Ү/х)	Тайлбар	Үнэлгээ
2.1	<p>Чанартай үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн холбогдох үүрэг хариуцлагыг тодорхойлсон дүрэм, журамтай эсэх</p> <p>(Чанарын хяналтын бодлого журмыг уншиж тухайн бичиг баримт нь ЧХОУС 1 "Чанарын хяналтын олон улсын стандарт", АБОУС3-өөс гаргасан "Аудитын Чанарын баримтлал", АОУС 220 "Санхүүгийн тайлангийн аудитын чанарын хяналт"-тай нийцэж буй эсэхийг үнэлж үнэлгээ өг)</p>			
2.2	<p>Компанийн тогтоосон чанарын хяналтын систем нь АОУС 220-д заасны дагуу (i) компани болон ажилтнууд нь мэргэжлийн стандартууд болон холбогдох холбогдох хууль тогтоомжийг мөрддөг (ii) компани болон гэрээт ажлын партнерууд нь нөхцөл байдалд тохирсон тайлан гаргадаг гэсэн ул үндэслэлтэй баталгаажуулалтыг хангахуйц зохиогдож, мөрдөгдөж байгаа эсэх?</p>			
2.3	<p>Аудитын чанарын үүрэг хариуцлагыг тухайн гэрээт ажлыг хариуцсан захирал, партнер хариуцаж, чанарт чухал нөлөө үзүүлдэг асуудлууд болох мэргэжлийн стандарт, хууль тогтоомжийн шаардлагыг баримталж ажлыг гүйцэтгэх, компанийн чанарын хяналтын бодлого журмыг мөрдөх, нөхцөл байдалд тохирсон аудитын тайлан гаргах, илрүүлэлтийн хариуд ирэх арга хэмжээнээс айлгүйгээр асуудлыг тавих аудитын багийн чадвар зэргийг чухалчлан үздэг эсэх?</p>			
2.4	Үзүүлж буй үйлчилгээнд чанар			

№	Асуулт	Хариулт Т/Ү/И(Ү/Х)	Тайлбар	Үнэлгээ
	зайлшгүй болохыг хүлээн зөвшөөрсөн дотоод соёлыг урамшуулан дэмжихэд чиглэсэн бодлого, горимыг бий болгосон эсэх?			
2.5	Компанийн чанарын хяналтын системийн эцсийн хариуцлагыг удирдах партнер эсвэл ерөнхий захирал (цаашид “компанийн дээд удирдлага” гэх) хариуцдаг эсэх?			
2.6	Ажилтнууддаа батлагдсан стандарт, горимуудад нийцүүлэн чанартай үйлчилгээ үзүүлэхэд дээд зэргээр чармайн ажиллахыг байнга дэмжиж, урамшуулдаг эсэх?			
2.7	Ахиц, дэвшил, сайжруулалтыг байнга урамшуулдаг, үйлчлүүлэгчээсээ үйлчилгээний гүйцэтгэлийн талаар санал асуулга, судалгаа авч, алдаа оноогоо шинжлэн сайжруулалт хийх бодлоготой эсэх?			
2.8	Ажлыг чанаргүй хийхэд хүргэж болзошгүй хэтэрхий хямд үнэ хөлстэй эсвэл танил талын нөлөө орсон гэж үзэж болохоор гэрээ эсвэл огт гэрээгүй ажил хийхийг хязгаарласан зохицуулалттай эсэх? (хэт бага үнэ хөлстэй эсвэл хэт богино хугацаа төлөвлөсөн ажлаас сонгож ажлын баримтын шалгалтад хамруулах замаар энэ асуултад хариул)			
2.9	Хөрөнгийн үнэлгээ, өмнөх аудитын ажил, үйлчлүүлэгчийн удирдлагын хийсэн нарийн төвөгтэй тооцоолол зэргийг аудитлаж баталгаажуулахад зориулсан тусгай аудитын хөтөлбөр бий эсэх?			
2	2-р хэсгийн бүлгийн нийт оноо			
Дээрх асуултуудад аль нэгэнд нь “Ү” гэсэн хариулт авсан, эсвэл “Т” хариулт авсан ч нотлох шалгалтаар батлагдаагүй бол тухайн хариултын нөлөөг үнэлэх замаар эдгээр үнэлгээний аль		Бүрэн Хангалттай		
		Хангалттай		
		Тодорхой нөхцөл хангасан тохиолдолд хангалттай		

№	Асуулт	Хариулт ТҮҮ(ү/х)	Тайлбар	Үнэлгээ
	тохиромжтойг сонгож эцсийн үнэлгээ өгнө.	Хангалтгүй		

Шалгалтын комисс:

Дарга

Гишүүд

/

/

/

/

/

/

Танилцаж зөвшөөрсөн

Гүйцэтгэх захирал

/

/

Хүснэгт 3: Ёс зүйн болон хараат бус байдлын үнэлгээний асуулгын хуудас

Зорилго: Энэхүү асуулгын хуудас нь “Аудитын хуулийн этгээдийн байгууллагын түвшинд Ёсзүйн болон хараат бус байдлын шаардлагыг хангаж буй эсэх”-ийг үнэлэхэд зориулагдсан.

№	Асуулт	Хариулт Т/Ү/И(ү/х)	Илрүүлэлт	Үнэлгээ
3.1	<p>Ёс зүйн болон хараат бус байдлын шаардлагуудтай холбоотой бичигдсэн горимууд бий юу?</p> <p><i>(Байгаа бол энэхүү дүрэм журам нь ДНБХ-ноос гаргасан Нийтэд үйлчилгээ үзүүлдэг нягтлан бодогчийн ёсзүйн дүрэм, хууль тогтоомжоор шаардсан бусад ёсзүйн шаардлагуудтай нийцэж буй эсэх болон дараах зүйлийг багтаасан эсэхийг үнэл)</i></p> <p><i>(i) Шулуун шударга байдал</i> <i>(ii) Бодитой хандлага</i> <i>(iii) Мэргэжлийн ур чадвар ба хянамгай байдал</i> <i>(iv) Нууц хадгалах байдал</i> <i>(v) Мэргэжлийн зан төлөв</i></p>			
3.2	<p>Хараат бус байдлыг хамарсан зохих ёс зүйн шаардлагуудтай холбоотой дотооддоо баталсан бичигдсэн бодлого, горимууд бий эсэх?</p> <p><i>(Тийм бол эдгээрийн хамгийн сүүлийн хувилбарыг авч танилц. Бодлого журам нь холбогдох олон улсын болон дотоодын хууль, тогтоомж, зохицуулалтын шаардлагад нийцэж буйг үнэл.)</i></p>			
3.3	<p>Компани эдгээр бодлого, горимуудыг байнга мөрддөг гэдгийг баталсан нотолгоо байгаа эсэх?</p> <p><i>(шат шатны хүмүүстэй хийх уулзалт, ярилцлага, компанид үүсгэсэн баримтжуулалтаар баталгаажуул)</i></p>			
3.4	<p>Энэ горимуудын талаарх мэдээллийг бүх партнерууд ба ажилчиддаа байнга мэдэгдэж, компанийн бүх ажилтны хүртээл, хэвшил болгосон эсэх?</p>			
3.5	<p>Энэ горимуудыг тогтмол шинэчилдэг эсэх?</p>			
3.6	<p>Эдгээр горимуудад үйлчилгээний үнэ хөлснөөс хараат байдалтай холбоотой дүрэм багтсан байна уу?</p>			

№	Асуулт	Хариулт Т/Ү/И(Ү/Х)	Илрүүлэлт	Үнэлгээ
	<i>(жилийн нийт орлогын 20%-иас давсан дүнтэй гэрээнүүдийг шинжилж, тийм бөгөөд эрсдэлтэй байж болох ажлуудыг шалгах ажлын баримт сонгохдоо харгалзах)</i>			
3.7	Байгууллагын хараат бус байдалд эсвэл партнерууд, ахлах ажилчдын хараат бус байдалд нүүрлэж болох боломжит аюулуудыг илрүүлэх систем компанид бий эсэх?			
3.8	Ажилчид анх аудитын ажилд томилогдохдоо үйлчлүүлэгчээс хараат бус болохоо бичгэн хэлбэрээр баталгаажуулдаг эсэх?			
3.9	Аудитын ажлын эхлэл ба төгсгөлд партнер ба ажилчид хараат бусаар ажиллах болон ажилласан болохоо баталгаажуулдаг байхыг албажуулсан эсэх?			
3.10	Бүх партнер ба ажилчид хараат бус байдлаа хадгалсан талаараа дор хаяж жилд нэг удаа бичгэн хэлбэрээр баталгаажуулдаг эсэх?			
3.11	Аудитын ажилд оролцсон хөндлөнгийн зөвлөхүүд гэх мэтийг хамарсан аудитын бус партнер ба ажилчдын хараат бус байдлыг баталгаажуулах бодлого бий эсэх?			
3.12	Горимууд, бодлогууд нь аудитын ротаци, баталгаажуулах ажилтай холбоотой дотоодын болон олон улсын хууль зохицуулалттай нийцэж байгаа эсэх?			
3.13	Баталгаажуулалтын болон баталгаажуулалтын бус үйлчилгээний төлбөр нь компанийн хараат бус байдлыг сулруулахад хүргэж болох тохиолдолд авах арга хэмжээг тусгасан тодорхой горимууд бий эсэх?			
3.14	Нягтлан бодох бүртгэлийг нь хөтлөх, хөрөнгийг нь үнэлэх, дотоод хяналтын системийг нь тогтоох, НББ-ийн бодлогыг нь боловсруулж өгөх, программ хангамжийг нь зохиож суурилуулах г.м еерийнхөө баталгаажуулж дүгнэлт гаргах ажлыг өөрсдөө хийхийг хориглосон зохицуулалттай эсэх?			

№	Асуулт	Хариулт Т/Ү/(ү/х)	Илрүүлэлт	Үнэлгээ
3.15	Үйлчлүүлэгчтэй холбоо тогтоохдоо танилын нөлөөнөөс зайлсхийх талаар баримталдаг бичгэн бодлого, журам бий эсэх?			
3.16	Авбал зохих оноо (ү/х хариулт орохгүй)			
3.17	3-р хэсгийн дэд дүн			
Дээрх асуултуудад аль нэгэнд нь “Ү” гэсэн хариулт авсан, эсвэл “Т” хариулт авсан ч нотлох шалгалтаар батлагдаагүй бол тухайн хариултын нөлөөг үнэлэх замаар эдгээр үнэлгээний аль тохиромжтойг сонгож эцсийн үнэлгээ өгнө.		Бүрэн Хангалттай		
		Хангалттай		
		Тодорхой нөхцөл хангасан тохиолдолд хангалттай		
		Хангалтгүй		

Шалгалтын комисс:

Дарга

Гишүүд

/

/

/

/

/

/

Танилцаж зөвшөөрсөн

Гүйцэтгэх захирал

/

/

Хүснэгт 4: Үйлчлүүлэгч хүлээн зөвшөөрөлтийн үнэлгээний асуулгын хуудас

Зорилго: Энэхүү асуулгын хуудас нь “Аудитын хуулийн этгээдийн байгууллагын түвшинд шинэ үйлчлүүлэгчийг хүлээн авах болон хуучин үйлчлүүлэгчийг үргэлжлүүлэх эсэхийг шийдвэрлэхэд баримталдаг бодлого горим”-ыг үнэлэхэд зориулагдсан.

№	Асуулт	Хариулт Т/Ү/(Ү/х)	Илрүүлэлт	Үнэлгээ
4.1	Үйлчлүүлэгч шинээр/үргэлжлүүлэн хүлээн зөвшөөрөхтэй холбоотой бичигдсэн горим бий эсэх? (Тийм бол энэхүү бодлого горим нь холбогдох олон улсын стандарт болон дотоодын хууль зохицуулалттай нийцэж буй эсэхийг үнэл.)			
4.2	Үйлчлүүлэгч хүлээн зөвшөөрөхтэй холбоотой бичигдсэн горимуудыг байнга сайжруулж, шинэчилдэг эсэх?			
4.3	Эдгээр горимуудыг бүх ажилчид, партнерууд мэдэж байгаа эсэх?			
4.4	Шинэ үйлчлүүлэгч хүлээн авахдаа өмнөх аудитораа сольсон шалтгааныг тодруулж, сольсон шалтгаан нь аудитын илрүүлэлттэй холбоотой санал зерелдөөнөөс үүдэлтэй биш гэдгийг тодорхойлж эрсдлийг үнэлэх журамтай эсэх?			
4.5	Шинэ үйлчлүүлэгч хүлээн авахдаа өмнөх аудитораа сольсон шалтгааныг тодруулж, сольсон шалтгаан нь аудитын цаг хугацааг хэт багаар тогтоож, аудитын горим гүйцэтгэх боломжийг хязгаарласантай холбоогүй гэдгийг тодорхойлж эрсдлийг үнэлэх журамтай эсэх?			
4.6	Үйлчлүүлэгчтэй гэрээ байгуулахдаа нарийн мэргэжлийн эксперт ба мэргэжилтнүүдийн бэлэн байдлыг харгалзаж үзэх шаардлагыг бодлого ба горимууд нь багтаасан эсэх?			
4.7	Ажил үйлчилгээний гэрээ байгуулахдаа хүний нөөцийн бэлэн байдлыг шинжилж шийдвэрлэдэг эсэхийг тодорхойлдог эсэх? (Тийм бол энэ шинжилгээ нь гаднаас ажиллах хүчин хөлслөхөд тавигдах шаардлага, нөхцлийг зохицуулсан эсэх)			
4.8	Шинэ үйлчлүүлэгчийн удирдлагын шударга байдлыг үнэлэхийг энэхүү			

№	Асуулт	Хариулт Т/Ү/И(Ү/Х)	Илрүүлэлт	Үнэлгээ
	бодлого журам нь шаарддаг эсэх?			
4.9	Үйлчлүүлэгч шинээр болон үргэлжлүүлэн хүлээн зөвшөөрөхдөө аливаа сонирхлын зөрчлийг илрүүлэх зохистой горимууд гүйцэтгэдэг эсэх?			
4.10	Үйлчлүүлэгчийн нэр хүндийг судлахыг үйлчлүүлэгчийг хүлээн зөвшөөрөх горим нь шаарддаг эсэх?			
4.11	Эрсдэл өндөртэй үйлчлүүлэгч хүлээн зөвшөөрөх үед баримтлах арга барилыг энэ бодлого журам нь зохицуулсан эсэх?			
4.12	Үйлчлүүлэгч эсвэл гэрээт ажлыг эрсдэл өндөртэй гэж ангилах шалгуурыг урьдчилан тодорхойлсон эсэх?			
4.13	Шинэ ажил эхлэх бүрт үйлчлүүлэгч хүлээн зөвшөөрөх стандарт загвар бүхий асуулгын хуудас ашиглахыг шаарддаг эсэх?			
4.14	Гэрээт ажлаас татгалзах талаар тогтсон шалгуур эсвэл горим бий эсэх?			
4.15	Ажилчдын мэргэшил, ур чадвар ба туршлагыг жагсаасан мэдээллийн сан бий эсэх?			
4.16	Хамгийн сүүлд гүйцэтгэсэн 3 үйлчлүүлэгч хүлээн зөвшөөрөх хуудсыг ав. Тэнд Мэргэжлийн ажилчдын туршлага ба ур чадвар, мэргэшилийг харгалзан үзсэн эсэхийг тодорхойл?			
4.17	Хамгийн сүүлд гүйцэтгэсэн 3 үйлчлүүлэгч хүлээн зөвшөөрөх хуудсыг ав. Тэнд сонирхлын зөрчлийг харгалзан үзсэн эсэхийг тодорхойл?			
4.18	Гэрээт ажлаас эсвэл үйлчлүүлэгчээс татгалзсан тохиолдол гарсан эсэхийг шалга. Энэ тохиолдолд ажлаас татгалзах горимуудыг гүйцэтгэсэн эсэхийг тодорхойл?			
	Үйлчлүүлэгч шинээр/үргэлжлүүлэн хүлээн зөвшөөрөхтэй холбоотой бичигдсэн горим бий эсэх? (Тийм бол энэхүү бодлого горим нь холбогдох олон улсын стандарт болон дотоодын хууль зохицуулалттай нийцэж буй эсэхийг үнэл.)			
4	4-р хэсгийн дэд дүнгийн онооны			

№	Асуулт	Хариулт Т/Ү/(Ү/Х)	Илрүүлэлт	Үнэлгээ
	нийлбэр			
	Дээрх асуултуудад аль нэгэнд нь “Ү” гэсэн хариулт авсан, эсвэл “Т” хариулт авсан ч нотлох шалгалтаар батлагдаагүй бол тухайн хариултын нөлөөг үнэлэх замаар эдгээр үнэлгээний аль тохиромжтойг сонгож эцсийн үнэлгээ өгнө.	Бүрэн Хангалттай		
		Хангалттай		
		Тодорхой нөхцөл хангасан тохиолдолд хангалттай		
		Хангалтгүй		

Шалгалтын комисс:

Дарга

Гишүүд

/

/

/

/

/

/

Танилцаж зөвшөөрсөн

Гүйцэтгэх захирал

/

/

Хүснэгт 5: Хүний нөөцийн үнэлгээний асуулгын хуудас

Зорилго: Энэхүү асуулгын хуудас нь “Аудитын хуулийн этгээдийн байгууллагын түвшинд Хүний нөөцийн талаар баримталдаг бодлого горим, түүний чанар”-ыг үнэлэхэд зориулагдсан.

№	Асуулт	Хариулт Т/Ү/(Ү/х)	Илрүүлэлт	Үнэлгээ
5.1	Мэргэжлийн стандартууд болон холбогдох зохицуулалт, хууль эрхзүйн шаардлагын дагуу аудитыг гүйцэтгэхэд шаардагдах ёс суртахууны зарчмуудыг хангасан, зохих мэдлэг, ур чадвар, туршлагатай хангалттай хүний нөөцтэй байх гэсэн шаардлагыг хүний нөөцийн бодлого журам нь тогтоосон эсэх?			
5.2	Компанийн хүний нөөцийн бодлого нь шинэ ажилтнуудыг ажилд томилохоос өмнө хангалттай түвшинд ажлаа хийх, бусадтай соёлтой бүтээлчээр харилцах чадварт сургах сургалт явуулж, мэдээлэл нотолгоо олж авах арга техникт сургадаг харилцааг зохицуулсан эсэх?			
5.3	Аудитын компанид хүний нөөцийн удирдлагыг хариуцсан нэгж эсвэл албан тушаалтан байдаг эсэх?			
5.4	Хүний нөөцийн удирдлагын бодлого нь доорх зүйлсийг багтаасан эсэх: (i) Шинээр ажилд авах (ii) Тогтвор суурьшилтай ажиллуулах (iii) Хувь хүний гүйцэтгэлийг үнэлэх (iv) Мэргэжлийн хөгжил, сургалт (v) Нийгмийн асуудал (vi) Гүйцэтгэлийг удирдах			
5.5	Гэрээт ажлын багийн хуваарилалттай холбоотой бичигдсэн горимууд бий эсэх? Горимууд нь зохистой эсэх?			
5.6	Партнеруудын үнэлгээ, цалин ба урамшуулалттай холбоотой бичигдсэн горимууд бий эсэх?			
5.7	Ажилчдын үнэлгээ, цалин ба урамшуулалттай холбоотой горимуудтай эсэх?			

№	Асуулт	Хариулт Т/Ү/(Ү/Х)	Илрүүлэлт	Үнэлгээ
5.8	Ажилтнуудын техник аргазүйн болон шат шатны удирдлагын ур чадварын дутагдлыг үнэлэх механизм байдаг эсэх? Тийм бол тухайн дутагдлыг засахад чиглэсэн арга хэмжээ авдаг эсэх?			
5.9	Партнер ба ажилчдын сургалттай холбоотой горим байдаг эсэх?			
5.10	Мэргэжлийн тасралтгүй боловсролыг хянах горимтой эсэх? Тийм бол түүнийг байнга шинэчилдэг эсэх?			
5.11	Ажилтнууддаа албан тушаалаа ахиулах, төлөвлөх, манлайлах боломжийг бүрдүүлсэн механизм тогтоосон эсэх?			
5.12	Ажилчдын гүйцэтгэлийг тодорхой хугацаанд үнэлдэг эсэх?			
5.13	Зохих ур чадвар ба чадамжтай ажилчдыг гэрээт ажилд хуваарилах зохистой систем бий эсэх?			
5.14	Мэргэжлийн ажилчдын туршлага ба мэргэшлийг тогтмол үнэлдэг эсэх?			
